ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР

# БАЙГУУЛЛАГЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар

***Баталгаажуулсан:***

*Орхон аймгийн Засаг дарга* *Б.ЗОРИГТБАЯР*

***Хяналт, шинжилгээ үнэлгээ хийсэн :***

*Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсийн дарга* *Ж. БААСАНСҮРЭН*

***Нэгтгэж тайлагнасан:***

*Нийгмийн даатгалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч* *Д.НАРМАНДАХ*

**ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН**
**2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| ***Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт.*** | | | | | | | |
| Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах | | | | | | | |
| 1.1.1. | Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах. | Шаард-лагагүй | Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо | Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой НДЕГ-аас 2023 онд ирүүлсэн 12 удаагийн зөвлөмжийн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан. | Дээд газраас ирүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байна. | 2024 оны байдлаар дээд шатны газраас ирүүлсэн 19 шийдвэр 18 журам, 25 зөвлөмж, 7 аргачлал чиглэлийн хэрэгжилтийг хангаж ажилласан.<br>Шилэн данс, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, стандартын хэрэгжилт, нийгмийн даатгалын шимтгэлийн тайлагнал, нөхөн төлөх журам, төрөл кодын залруулга, сайн дурын даатгал, малчин иргэдийн хамрагдалт нэмэгдүүлэх, цалингийн мэдээллийг хөрвүүлэх гэх мэт чиглэл зөвлөмжүүдийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж тайлан, судалгааг хугацаанд нь хүргүүлж ажилласан байна.<br>Нийгмийн даатгалын багц хуулийн танилцуулга сургалт, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Portal.ndaatgal.mn ажил олгогчийн цахим системийн заавар чиглэл, гадагшаа чиглэсэн сургалтыг 1310 аж ахуй нэгж байгууллагад мэдээллийг хүргэж, 16 ААНБ-д сургалт зохион байгуулж, 597 даатгуулагчийг хамруулан зөвлөгөө хүргэн, Нийгмийн даатгалын багц хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр гарсан дүрэм, журам, аргачлал, зөвлөмжийн хүрээнд албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх, чадавхжуулах 48 удаагийн сургалтыг зохион байгуулж мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажилласан байна. | |
| 1.1.2. | Сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, малчид, албан бус хөдөлмөр эрхлэгчдийг сайн дурын даатгалд шинээр хамруулах, хамралтын төлөвлөгөөг биелүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг тогтоосон хугацаанд хүргүүлэх. | Шаард-лагагүй | Сайн дурын даатгалд шинээр хамруулсан даатгуулагч (малчин)-ийн тоо, дээд газарт хүргүүлсэн мэдээ, тайлангийн тоо | 2023 онд 601 хүнийг сайн дурын даатгалд шинээр, үүнээс 32 малчин шинээр хамруулав. | Сайн дурын даатгуулагч (малчин)-ийн тоог өмнөх оноос 135 хүнээр нэмэгдүүлж, төлөвлөгөөг биелүүлсэн байна. | Нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэн 2024 онд Нээлттэй хаалганы өдөрлөгийг 9 удаа зохион байгуулж, Хүнс хөдөө аж ахуйн газартай хамтран 11 чиглэлд 3 удаагийн явуулын үйлчилгээ үзүүлэн нийт 838 иргэд, даатгуулагчдад мэдээлэл хүргэн ажилласан байна.<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчид чиглэсэн 34 удаагийн сургалтад 1015 иргэд, даатгуулагчийг хамруулсан.<br>Сайн дурын даатгалд хамруулах иргэдийн тооны төлөвлөгөө 733 байхаас нийт 1566 иргэнийг даатгалд хамруулж 213%-ийн биелэлттэйгээр гүйцэтгэсэн байна. Үүнд: | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Энгийн СДДаатгуулагч – 1155<br>• 0-3 настай хүүхдээ асарч байгаа эх – 153<br>• Малчин даатгуулагч – 127<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг эх - 131 хамруулж ажилласан байна | |
| 1.1.3. | Албан журмын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн даатгалд хамрагдаагүй ажил олгогч, даатгуулагчдыг шинээр хамруулах, хамралтын төлөвлөгөөг биелүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг тогтоосон хугацаанд хүргүүлэх. | Шаард-лагагүй | Албан журмын даатгалд шинээр хамрагдсан ажил олгогч, албан журмын даатгуулагчийн тоо | 2023 онд 103 ажил олгогч, 626 хүнийг албан журмын даатгалд шинээр хамруулав. | Ажил олгогчийн тоог 117, даатгуулагчийн тоог 660 нэмэгдүүлж, төлөвлөгөөг биелүүлсэн байна. | Нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, ХХАА-газар, Халамж үйлчилгээний газар, Татварын хэлтэстэй хамтран ажиллаж шинээр 202 аж ахуйн нэгж байгууллагыг бүртгэж нийгмийн даатгалд хамруулсан байна. Ажил олгогч-117 хамруулахаас 202 ААНБ-ын 626 даатгуулагчийг хамруулан төлөвлөгөөг 172 хувьтай биелүүлэн ажилласан байна. | |
| ***Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт*** | | | | | | | |
| Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, өр, авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, нийгмийн даатгалын сангийн хуримтлал бий болгох, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах | | | | | | | |
| 2.1.1. | Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг мөрдөж ажиллах. | Шаард-лагагүй | Нийгмийн даатгалын сангийн 2024 оны орлого, зарлагын гүйцэтгэл | Нийгмийн даатгалын санд 2023 онд 167,897.1 сая төгрөг буюу 97.89 хувиар орлого төвлөрүүлж, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардалд 168,833.4 сая төгрөг буюу 96.9 хувийн | Батлагдсан төсвийн хуваарь, дээд газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг мөрдөж ажилласан байна. | Нийгмийн даатгалын санд 2024 оны жилийн эцсийн байдлаар орлогын төлөвлөгөө 172,462.5 сая төгрөг буюу 94.02 хувиар биелүүлж, 169,036.1 сая төгрөгийг төв санд төвлөрүүлсэн. Тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардалын төлөвлөгөө 221,274.6 сая төгрөгөөр 100.43 хувийн биелэлттэй зарцуулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | биелэлттэй зарцуулсан. | | | |
| 2.1.2. | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, НДЕГ-ын даргын баталсан нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг мөрдөж ажиллах. | Шаард-лагагүй | Нийгмийн даатгалын байгууллагын 2024 оны үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн гүйцэтгэл | Нийгмийн даатгалын байгууллагын 2023 оны үйл ажиллагааны урсгал зардалд 1116.3 сая төгрөг зарцуулсан. | Батлагдсан төсвийн хуваарь, дээд газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг мөрдөж ажилласан байна. | 2024 оны жилийн эцсийн байдлаар үйл ажиллагааны урсгал зардалд 1,566,7 сая төгрөг зарцуулж 25.0 сая төгрөгийг хэмнэж ажилласан байна. | |
| 2.1.3. | Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөг жигд хангаж биелүүлэх. | | Батлагдсан 178 460 395.50 төгрөгийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг сараар, өссөнөөр жигд биелүүлэн ажиллана. | Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд хангаж биелүүлж, нийгмийн даатгалын сангийн орлогыг 144 303 542.54 мян.төгрөгөөр буюу 97.61 хувиар биелүүлсэн. | Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд хангаж биелүүлж, нийгмийн даатгалын санд 178 460 395.50 төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна. | Нийгмийн даатгалын санд 2024 жилийн эцсийн байдлаар орлогын төлөвлөгөөг 172,462.5 мян төгрөгөөр буюу 94.02 хувиар биелүүлж, 169036.1 сая төгрөгийг төв санд төвлөрүүлсэн. | |
| 2.1.4. | ЭМДЕГ-аас ирүүлсэн эрүүл мэндийн даатгалын сангийн ажил олгогчийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөг жигд хангаж биелүүлэх. | | ЭМДЕГ-аас ирүүлсэн орлогын төлөвлөгөө биелсэн байна. | ЭМД-ын сангийн орлого 9 066 022.62 төгрөг төвлөрсөн байна. | ЭМД-ын сангийн орлогын төлөвлөгөө 100 хувь биелсэн байна. | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024.02.01-ний өдрийн 05/241 албан бичгийн дагуу эрүүл мэндийн даатгалын төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажиллаж жилийн эцсийн байдлаар 31,027.1 сая төгрөг төвлөрүүлж 94.3 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хувийн биелэлттэй байна. | |
| 2.1.5. | Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг бууруулах ажлыг зохион байгуулж оны эхний үлдэгдэлээс бууруулах, үр дүнг тооцож газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, тайланг НДЕГ-т хүргүүлэх. | | Ажил олгогчоос төлөх шимтгэлийн авлагыг оны эхний дүнгээс 30-аас доошгүй хувиар бууруулна. | Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн авлага оны эхнээс -3.87 хувиар буурсан байна. | Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн авлагыг оны эхний дүнгээс 30 хувиас доошгүй буурсан байна. | Нийгмийн даатгалын шимтгэлийн оны эхний өр, авлага 5,576,596.43 мян төгрөг байснаас 3,030,284.61 мян төгрөг буюу 54.34 хувь бууруулж ажилласан байна.<br>• Уулзалт хийсэн – 29 ААНБ 363.28 сая төгрөг<br>• Сануулах арга хэмжээ – 1018 ААНБ 4,579.07 сая төгрөг<br>• Албан шаардлага – 10 ААНБ 91.12 сая төгрөг<br>• Данс хаасан – 402 ААНБ 2,580.62 сая төгрөг<br>• Гэрээ байгуулсан – 20 ААНБ 1,222.12 сая төгрөг<br>• Хууль хяналтын байгууллагад – 3 ААНБ 135.65 сая төгрөг<br>Нийт 8,871.89 сая төгрөгийн шимтгэлийн авлагад ХНХСайдын 2023.12.25-ны өдрийн А/199 журам хэрэгжүүлэн ажиллаж байна. | |
| 2.1.6. | Сайн дурын даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг барагдуулах | | Сайн дурын даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөггүй гарсан байна. | Сайн дурын даатгуулагчийн шимтгэлийн тооцоог хийсэн. | Сайн дурын даатгуулагчийн шимтгэлийн тооцоог тухай бүр хийж, өглөггүй байна. | 2024 оны жилийн эцэст Сайн дурын даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөггүй тооцоо гаргасан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.7. | Бусад өглөг, авлагыг барагдуулах | | Ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн өглөг авлагаас бусад өглөг, авлагыг хугацаанд нь барагдуулна. | Бусад өглөг авлага санхүүгийн тайлангаар баталгаажсан байна. | а) Нийгмийн даатгалын сангийн бусад өр, авлагыг оны эхний дүнгээс 50 хувиас доошгүй барагдуулах.<br>б) Нийгмийн даатгалын байгууллагын бусад өр, авлагыг бүрэн барагдуулах. | Нийгмийн даатгалын сангийн бусад авлага 2024 оны эцэст 38.5 сая төгрөг болж 0,8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь 0-30 хоногийн насжилттай авлага болно.<br>Мөн өглөг оны эхэнд 6.8 сая төгрөг байсан бөгөөд жилийн эцсийн байдлаар 20 иргэн, хуулийн этгээдтэй холбоотой 5.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. ЭМД-ын сан ЭМЯ-нд шилсэнтэй холбоотойгоор 51 иргэний 1.7 сая төгрөгийг ЭМД-ын сан руу шилжүүлж тооцоо нийлсэн. | |
| 2.1.8. | НДЕГ-ын даргын 2023.12.26-ны өдрийн А/183 тоот тушаалаар батлагдсан "Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, санхүүжилт олгох, хяналт тавих журам"-ын 3.3 дах заалтыг хэрэгжүүлж ажиллах. | | НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр бүрэн төвлөрүүлнэ. | | НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр бүрэн төвлөрүүлсэн байна. | Нийгмийн даатгалын санд 2024 жилийн эцсийн байдлаар орлогын төлөвлөгөөг 172,462.5 мян төгрөгөөр буюу 94.02 хувиар биелүүлж, 169036.1 сая төгрөгийг төв санд төвлөрүүлсэн. | |
| 2.1.9. | Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулах. | | Хууль тогтоомжийн дагуу иргэд даатгуулагчдад 174230.9 сая төгрөгийн | Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулсан. | а) Тэтгэврийг сар бүрийн 01-ний өдөр олгох<br>б) Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төсвийн дагуу | Тэтгэвэр тэтгэмж төлбөр зардлын тухайд 2024 оны байдлаар 220,318.6 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн бөгөөд 221,274.6 сая төгрөгийг зарцуулсан байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тэтгэвэр тэтгэмж төлбөр зардлыг хугацаанд нь олгоно. | | 168883.4 сая төгрөгийг хуульд заасан хугацаанд зарцуулсан байна. | | |
| 2.1.10. | Батлагдсан зардлын төсөв, хөрөнгө оруулалтын зардлын үр ашгийг дээшлүүлж, хэмнэлтийн зарчмыг баримтлах. | | Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн зарцуулахгүй, ажиллагсадтай холбоотой болон бусад өр авлагагүй ажиллана. | Батлагдсан 1180.1 сая төгрөгийн төсвийг зардлын ангиллын дагуу 1116.3 сая төгрөг зарцуулсан. | а)Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх. б)Батлагдсан төсвийг зардлын ангиллын дагуу зарцуулах в) Ажиллагсадтай холбоотой цалин, шимтгэл, татвар болон бусад өр авлага үүсгээгүй байна. | Нийгмийн даатгалын байгууллагын 2024 оны жилийн эцсийн байдлаар үйл ажиллагааны урсгал зардлын төлөвлөгөө 1,591.7 сая төгрөг байсан ба зардлын ангилалын дагуу 25.0 сая төгрөгөөр хэмнэж зарцуулсан байна. | |
| 2.1.11. | Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөх, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, санхүүгийн тайлан гаргах ажлыг зохион байгуулах | | Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд хүргүүлнэ. | Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, | Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн өр авлагын сарын мэдээг үнэн зөв гаргаж, хугацаанд нь хүргүүлсэн байна. | Хуульд заасан цаглабарын дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газар болон аймгийн холбогдох байгууллагуудад санхүүгийн 12 удаагийн мэдээ, 4 удаа тайланг гаргаж хугацаанд нь хүргүүлсэн байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн өр авлагын сарын мэдээг гаргаж, ирүүлсэн. | | | |
| 2.1.12. | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, ил тод тайлагнах. | | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнаж ажиллана. | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнасан байна. | -Үндсэн хөрөнгө актлах, шилжүүлэх үйл ажиллагааг хууль дүрэм, журамд нийцүүлэн өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт, холбогдох баримтыг үндэслэн хөрөнгийн нэмэгдэх, хасагдах хөдлөлийг цаг тухай бүрд нь бүртгэлд тусгах;<br>-Эзэмшил газар, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, үндсэн хөрөнгө г.м/ нэгдсэн судалгааны маягтууд ТӨХ /ТӨХ-1-с ТӨХ-11 маягт/ болон мэргэжлийн байгууллагад гаргаж өгдөг мэдээ тайланг хуулийн хугацаанд мэдээлэх;<br>-Хагас болон бүтэн жилийн тооллогоор үнэ тогтоолгох, шилжүүлэх, актлах, хөрөнгийн жагсаалтыг | 2024 оны жилийн эцсийн байдлаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 06 сарын 14-ны өдрийн "Журам шинэчлэн батлах тухай" А/92 тушаалыг үндэслэн өмч хамгааллын байнгын зөвлөл үндсэн хөрөнгийн тооллогийг журмын дагуу хийж тайлан, мэдээ, судалгааг холбогдох газруудад хуулийн хугацаанд хүргүүлж ажилласан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тогтоосон хугацаанд хүргүүлэх;<br>-Хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, үндсэн хөрөнгө, маягтын тооллого хийх ажлыг зохион байгуулж, дүнг хугацаанд нь хүргүүлэх;<br>-Өмч хамгаалах байнгын зөвлөл журмын дагуу ажиллуулах;<br>-Үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн тайланг "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем" програмд дараа оны 3 дугаар сарын 5-ны дотор оруулах;<br>-Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангах, Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний орлогыг санд бүрэн төвлөрүүлсэн байна. | | |
| | Төсвийн тухай хууль тогтоомжийн | | Өөрчлөлтгүй дүгнэлт авах, | а) Нийгмийн даатгалын | а) Нийгмийн даатгалын сангийн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.13. | хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, Аудитын байгууллагаас "Өөрчлөлтгүй" дүгнэлттэй ажиллах. | | зөвлөмж, акт, албан шаардлагыг хугацаанд нь бүрэн биелүүлнэ. | сангийн санхүүгийн тайлангийн Аудитын шалгалтаар өөрчлөлтгүй дүгнэлт авсан. б) Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна. | санхүүгийн тайлангийн Аудитын шалгалтаар "Өөрчлөлтгүй" дүгнэлт авах. б) Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг 100.0 хувь биелүүлсэн байна. | Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, Аудитын байгууллагаас "Өөрчлөлтгүй" дүгнэлттэй ажилласан. | |
| 2.1.14. | Нийгмийн даатгалын ерөнхий газраас банкуудтай байгуулсан ерөнхий гэрээг хэрэгжүүлэх, дүгнэх, биелэлтийг НДЕГ-т хүргүүлэх. | | Нийгмийн даатгалын ерөнхий газраас арилжааны банкуудтай байгуулсан "Хамтран ажиллах гэрээ"-г хэрэгжүүлэн, хэрэгжилтийг дүгнэн НДЕГ-т хүргүүлнэ. | Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангаж ажилласан. | а) Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах. б) Гэрээний хэрэгжилтийг дүгнэж, дүнг НДЕГ-т хүргүүлсэн байна. | Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Орхон аймагт үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны банкуудтай байгуулсан 2023 оны гэрээг 2024.01.04-ний өдөр зүйл заалт бүрээр дүгнэж, биелэлтийг тухайн НДЕГ-т хүргүүлсэн ажилласан бөгөөд 2024 онд хамтран ажиллах гэрээг 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдөр байгуулж гэрээний хэрэгжилтийг 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн дотор дүгнэж НДЕГ-т хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. | |
| | Нийгмийн даатгалын сангийн цахим | | Холбогдох хууль | Нийгмийн даатгалын | а) Анхан шатны болон нягтлан бодох | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.15. | мэдээллийн санг тухай бүр үнэн зөв бүрдүүлэх. | | тогтоомжийн дагуу мэдээллийг үнэн зөв оруулж бүртгэнэ. | сангийн мэдээллийн баазыг тогтоосон хугацаанд хаалт хийлгэсэн. | бүртгэлийг цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэх ажлыг зохион байгуулж, бүртгэлийн алдаа, залруулга гаргахгүй байх.<br>б) Ажил олгогч, даатгуулагчийн мэдээллийг үнэн зөв бүртгэж мэдээллийн сан бүрдүүлсэн байна. | Нийгмийн даатгалын системийн цахим мэдээллийн сан илүү ухаалаг түвшинд шилжиж байгаатай холбоотойгоор шинэ болон хуучин программ хангамжуудыг давхар ашиглаж алдаа, залруулга гаргахгүйгээр ажиллаж байна. | |
| 2.1.16. | Нийгмийн даатгалын мэдээллийн систем хөгжүүлэх" төслийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн шинэчлэлтэй холбоотой ажлыг хэрэгжүүлэх. | | ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн Төслийн багтай хамтран Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг "Core" системээр хөтлөх ажлыг хийж гүйцэтгэнэ. | ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн Төслийн багаас зохион байгуулсан ажлуудад оролцсон. | Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг "Core" системээр хөтлөх ажлын гүйцэтгэлийг хангаж ажилласан байна. | Шинэ системийн шинэчлэлт, сайжруулалттай холбоотой тулгамдсан асуудлуудыг Нийгмийн даатгалын газарт цаг тухай бүрт уламжлан Ай Ти Зон ХХК-ний программистуудаар алдааг засварлуулан ажиллаж байна. Тус газраас системийн 12 алдааг илрүүлж засварлуулсан. | |
| 2.1.17. | Нягтлан бодох бүртгэлийн тооцооны өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар шинэчлэн баталгаажуулах | | Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлж, тооцоо нийлсэн актаар баталгаажуу | Тооцооны үлдэгдлийг баталгаажуулсан. | а) Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулах.<br>б) Нийгмийн | Нийгмийн даатгалын сангийн харилцах дансны үлдэгдлийг арилжааны банкуудтай тооцоо нийлэн баталгаажуулж, сангийн бусад өглөг, авлагыг холбогдогч, байцаагч ажилтнуудаар гарын үсэг зуруулан баталгаажуулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | лна. | | даатгалын сангийн санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулсан байна. | | |
| 2.1.18 | ЭМД-ийн шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг даатгуулагчтай холбоотой өглөг авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж ЭМДЕГ-т хүргүүлэхтэй холбоотой холбогдох ажлуудыг хэрэгжүүлэх | | Эрүүл мэндийн даатгалын сангийн харилцах дансуудыг хаах, харилцах дансны үлдэгдэл болон тайлангаар гарсан авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулна. | Харилцах дансны үлдэгдэл болон санхүүгийн тайлангаар баталгаажуулсан авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан. | а) ЭМД-ын харилцах дансуудыг хаах, харилцах дансны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.<br>б) Эрүүл мэндийн даатгалын авлага, өглөгийн тайлангийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулсан байна. 3903 дансны үлдэгдлийг даатгуулагч тус бүрээр жагсаалт үйлдэж НДЕГ-т ирүүлсэн байна.<br>в) 3303 дансанд бүртгэлтэй ЭМД-ын ташаарсан орлогыг жагсаалт үйлдэж тооцоо нийлж баталгаажуулан НДЕГ-т ирүүлнэ. | Эрүүл мэндийн даатгалын сангийн авлага үүсгэлгүй, өглөгийн тооцоог гарган НДЕГ-т хүргүүлсэн бөгөөд Нийт өглөг 1058 хүний 11,2 сая төгрөгийг ЭМЯ-руу шилжүүлэхээр хүн нэг бүрээр тооцоог гарган нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлж ажилласан. | |
| ***Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт*** | | | | | | | |
| Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.1. | Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтэд хяналт тавих; | - | Нийтийн ил тод мэдээллийн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.6 дугаар заалтын дагуу 48 мэдээллийг вебсайт хуусанд бүрэн, үнэн, зөв байршуулан ажлын тайланг ДАМГ-т 2024 оны 07 дугаар сарын 09, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ. | Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу 48 мэдээллийг 2023 оны байдлаар 59.5 хувьтай байршуулсан. | Байгууллагын нээлттэй мэдээллийг ил тод болгож, иргэдийн мэдээлэл хайх, хүлээж авах эрхийг хангасан байна. | Цахим хуудсанд бүрэн оруулаагүй дутуу оруулсан 8.2.8, 8.2.9, 8.3.1 мэдээллийг бүрэн оруулж, шинэчлээгүй байсан 8.2.2, 8.2.6, 8.3.2, 8.3.3, 8.3.4, 8.3.6, 8.5.1 мэдээллийг шинэчлэн оруулснаас гадна хүний нөөцийн болон судалгаа, тоон үзүүлэлттэй, цаг үеийн шинжтэй мэдээллийг тухай бүр шинэчлэн байгууллагын нээлттэй 48 мэдээллийг бүрэн оруулж, мэдээллийн самбарт байршуулан ил тод болгож, иргэдийн мэдээлэл хайх, хүлээж авах эрхийг хангаан ажилласан. Аймгийн ЗДТГ-ын 02/3252 тоот албан бичгийн дагуу сургалтад сууж, холбогдох мэргэжилтнээс зөвлөгөө авч тайлагнахдаа гаргасан алдаагаа залруулах арга хэмжээг авч ажилласан. | |
| 3.1.2. | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих; | - | Нийгмийн даатгалын байгууллагын сан, үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хагас жилийн байдлаар 85 мэдээллийг 07 дугаар | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, 167 мэдээллийг 2023 оны байдлаар 95.7 хувьтай хугацаандаа мэдээлэл байршуулсан. | Нийгмийн даатгалын байгууллагын санхүү болон сангийн мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулж, иргэдийг үнэн, зөв мэдээллээр хангасан байна. | Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн 91, сангийн 64 мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулж, иргэдийг үнэн, зөв мэдээллээр хангаан ажилласан бөгөөд 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар нийт 155 мэдээллийг байршуулсан байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | сарын 09-ны өдрийн дотор, жилийн эцсийн байдлаар 167 мэдээллийг Shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулан ДАМГ-т 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ. | | | | |
| Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч, иргэн болон нийгмийн даатгалын орон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж шийдвэр гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах | | | | | | | |
| 3.2.1. | Нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг дээд газраас өгсөн чиглэлийн дагуу болон газрын даргын баталсан удирдамжийн дагуу аж ахуйн нэгж, байгууллага болон дотоодын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах. | Шаард-лагагүй | Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг шалгаж, илэрсэн төлбөр, зөрчлийн 70.0 аас доошгүй хувийг барагдуулж ажиллана. | Илэрсэн төлбөр зөрчлийн 72,6 хувийг барагдуулж ажилласан. | Шалгалтын үр дүнг тухай бүрд нь тооцон, газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулан актаар тогтоогдсон төлбөрийн 70-аас доошгүй хувийг барагдуулсан байна. | Дээд газраас өгсөн 7 чиглэл:<br>1. Стандартын хэрэгжилт<br>2. НДЕГ-ын даргын А/133 тоот зөвлөмжийн хэрэгжилт<br>3. Нийтийн ил тод мэдээллийн байдлын тухай хуулийн хэрэгжилт<br>4. Шилэн дансны хуулийн хэрэгжилт<br>5. Шинэ программ нэвтэрсэнтэй холбоотой 2024 оны 01-11 саруудад олгосон нийт тэтгэвэр, тэтгэмжийн олголтын хэрэгжилт<br>6. Өргөдөл гомдлын шийдвэрлэлт<br>7.Олон улсын гэрээ болон тусламжаар үйл ажиллагаа явуулдаг ААНБ шалгах | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 8. ҮОМШӨ-ний сангийн бүрдүүлэлт, зарцуулалт<br>9. Уул уурхай, олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ААНБ шалгах<br>Газрын даргын удирдамжийн дагуу:<br>1. Албан хэрэг хөтлөлт болон архивын үйл ажиллагааг шалгах<br>2. Жаргалант сумын үйл ажиллагааг шалгах<br>Дотооддоо 8, гадагшаа 3 чиглэлээр нийт 11 шалгалт хийж, шалгалтын илэрсэн 73.9 сая төгрөгийн төлбөрийн зөрчлөөс 49,7 сая төгрөгийг буюу 67,25% барагдуулж ажилласан. | |
| 3.2.2. | Хил хамгаалах ерөнхий газартай 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан 03/НД-22/23 дугаартай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд зохион байгуулж хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг нэгтгэж дүгнэх, | Шаард-лагагүй | Хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд зохион байгуулж хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнг хагас, бүтэн жилээр аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудаас гаргуулан авч нэгтгэж дүгнэх, | Хил хамгаалах ерөнхий газартай хамтран ажиллах санамж бичгийг 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр шинэчлэн байгуулсан. | Холбогдох судалгаа, тооцоо, дүгнэлтэд үндэслэн Хилийн цэргийн анги, тусгай салбартай хамтарсан шалгалт хийж үр дүнг тооцож, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж ажиллах | 2024 оны 04 дүгээр сарын 18 өдрийн 06/809 тоот ЗХ-ний жанжин штабын дарга, НДЕГ-ын даргын хамтарсан тушаалын дагуу ЗХ-ний 210 дугаар ангид 1995-1997 он хооронд алба хаасан 401 цэргийн албан хаагчийн овог нэр, регистерийн дугаарыг бүрдүүлэх ажлын хүрээнд 380 цэргийн албан хаагчийн мэдээллийг бүрдүүлэн жагсаалтыг хуваарийн дагуу хугацаанд нь хүргүүлж, тайлант хугацаанд ЗХ-ны 110-р ангид алба хааж байсан 2 албан хаагчтай холбоотой, ЗХ-ны 186-р ангид алба хааж байсан 3 албан хаагчтай холбоотой нийт 116.5 мянган төгрөгийн шимтгэл алдангийг нөхөн төлүүлж шийдвэрлэсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2.3. | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн 2021-2023 оны орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт шалгалт хийх | | 21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд ҮОМШӨ-ний сангийн зарцуулалтад хяналт шалгалт хийж илэрсэн зөрчилд хуулийн дагуу хариуцлага тооцож, үр дүнд хяналт тавьж ажиллах, | - | ҮОМШӨ-ний сангийн бүрдүүлэлт, зарцуулалтыг мэдээллийн нэгдсэн сангийн өгөгдөл болон анхан шатны баримтад тулгуурлан шалгаж, илэрсэн зөрчлийн 80 хүртэл хувийг барагдуулж ажиллах | ҮОМШӨ-ний сангийн бүрдүүлэлт, зарцуулалтыг 2021 оны 5 хавтас, 2022 оны 5 хавтас, 2023 оны 6 хавтас, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийн 390 хувийн хэрэг, тэжээгчээ алдсаны тэтгэврийн 35 хувийн хэрэг, 2021-2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан 2 хавтас, 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан зэрэг анхан шатны баримтад тулгуурлан шалгаж, 2 тэтгэвэр авагчийн тэтгэврийн төрлийг хэвийнээс ҮОМШӨ болгож залруулахыг үйлчилгээний тасгийн даргад даалгаж, 1 тэтгэвэр авагчийн үйлдвэрлэлийн ослын акт байхгүй байсныг илрүүлж иргэнээс нь авч хувийн хэрэгт хавсарган илэрсэн 2,05 сая төгрөгийн төлбөрийн зөрчлийг 100 хувь барагдуулж ажилласан. | |
| 3.2.4. | Нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектод төлөвлөгөөт шалгалт хийх | | Хяналт шалгалт хийсэн объектын тоогоор , гүйцэтгэлийн хувь, хууль сахин мөрдөлтийн түвшин, илрүүлсэн зөрчил, | - | Их, дунд эрсдэл бүхий аж ахуйн нэгж байгууллагын 80 хүртэл хувийг шалгаж, ирэлсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулах | Төлөвлөгөөнд тусгасан 15 байгууллагаас 15 ажил олгогчид төлөвлөгөөт шалгалт хийж, шалгалтын явцад 2 байгууллага дээр зөрчлийн хэрэг нээж 2000 нэгжээр торгох шийтгэл оногдуулж, 4 даатгуулагчийн 1.6 сая төгрөгийн хохирол нөхөн төлбөрийг 100% төлүүлэн буруу тайлагнасан, даатгуулагч орхигдуулсан зөрчлийн нөхөн залруулан ажилласан | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | арилгуулалтын хувь, Улсын байцаагчийн шийдвэрийн биелэлт, Эрсдэлийн түвшин буурсан объектын тоо, хувь | | | | |
| 3.2.5. | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2019 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/50 дугаар тушаалаар баталсан "Цахим хяналт, шалгалтын ажлын заавар"-ын дагуу цахим мэдээлэлд тулгуурлан хийх хяналт, шалгалтыг тогтмолжуулах, | | Нийгмийн даатгалын салбарын "Цахим хяналтын веб програм"-(http://10.9.0.5/monitoring)-д тулгуурлан хяналт, шалгалтыг сар бүр тогтмол хийж "Цахим хяналт, шалгалтын ажлын заавар"-ын 3.4-т заасан хугацаанд холбогдох газарт хүргүүлнэ. | Аймгийн хэмжээнд цахим хяналт, шалгалтыг тогтмолжуулж, илэрсэн зөрчлийн 80,0 доошгүй хувийг шалгаж, залруулсан. | Нийгмийн даатгалын салбарын "Цахим хяналтын веб програм"-(http://10.9.0.5/monitoring)-аас тодорхой өгөгдлийн дагуу шүүлт хийж, зөрчилтэй байх магадлалтай мэдээллийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу шалгаж шийдвэрлэсэн байна. | Нийгмийн даатгалын салбарын "Цахим хяналтын веб програм"-(http://10.9.0.5/monitoring)-аас тодорхой өгөгдлийн дагуу шүүлт хийж, зөрчилтэй байх магадлалтай мэдээллийг Нийгмийн даатгалын байгууллага шинэ систем нэвтэрч байгаа үйл ажиллагаатай холбоотой хянах боломжгүй байна. | |
| 3.2.6 | Дотоодын хяналт, шалгалтын тайланг хагас бүтэн жилээр | | Дотоодын хяналт, шалгалтын | | Шалгалтын үр дүнг газрын даргын зөвлөлийн хурлаар | Дотоод хяналт шалгалтаар 18 улсын байцаагчийн акт үйлдэж 8.7 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үнэн зөв гаргаж нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлантай тулган баталгаажуулах, Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалт, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тооцож тайлан, мэдээг заасан хугацаанд хүргүүлэх, | | хагас жилийн болон жилийн тайланг Нийгмийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн дагуу, Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалт, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг улирал тутамд гаргаж Хяналт, шалгалтын газарт хүргүүлнэ. | | хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулан актаар тогтоогдсон төлбөрийн 70-аас доошгүй хувийг барагдуулсан байна. | сая төгрөгийн төлбөрийг бүрэн барагдуулан, зөрчлийн 44 хэргийг бүртгэл авч 41.6 сая төгрөгийн төлбөр, 9.5 сая төгрөгийн торгуулийг 100% барагдуулан ажилласан. Өмнөх оны 10.3 сая төгрөгийн авлагыг 38,8% бууруулан 6.3 сая төгрөг болгон ажилласан байна. | |
| ***Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт.*** | | | | | | | |
| Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах | | | | | | | |
| 4.1.1. | Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, тушаал шийдвэр болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, ажил үйлчилгээний хэрэгжилт, тайлан, дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх. | | Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, зөвлөмж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна. | 2023 оны жилийн эцсийн байдлаар НДЕГ-аас өгсөн үүрэг даалгавар, тогтоол шийдвэр, чиглэл зөвлөмж, үйл ажиллагааны тайлан, зорилтот жилийн төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн авч дүгнэхэд хэрэгжилт 83,5%-тай хэрэгжсэн байна | Өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь хэрэгжүүлж, биелэлтийг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ. | 2024 оны байдлаар:<br>- МУ-ын Засгийн газрын тогтоол-13,<br>- Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны сайдын тушаал-9,<br>- Аймгийн Засаг даргын захирамж-4<br>- Аймгийн ИТХ-ын тогтоол-3<br>- Нийгмийн даатгалын Үндэсний Зөвлөлийн тогтоол-9<br>- Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын тушаал-18<br>- Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын тушаал 1 хяналтандаа авч хэрэгжүүлэн ажиллаж байна.<br><br>Тайлан мэдээг судалгаа хагас жилийн байдлаар гаргаж заасан хугацаанд хүргүүлэн ажилласан. | |
| 4.1.2. | ААНБ, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг | | Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх | Иргэд, байгууллагаас ирсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэлт 2023 онд 89,1 %- | Иргэд, даатгуулагч, ААНБ-аас ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд бүрэн барагдуулж, мэдээг үнэн бодит | 2024 оны байдлаар цахимаар болон цаасан хэлбэрээр иргэд, даатгуулагчдаас нийт 130 санал, хүсэлт ирснээс Тэтгэвэр | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулах, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнах. | | ажлыг зохион байгуулж, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнасан байна. | тай хэрэгжсэн байна. | гаргаж улирал бүрийн сүүлийн сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ. | тогтоолттой холбоотой өргөдөл 36, ЭХМК-той холбоотой өргөдөл 23, НДШ нөхөн төлүүлэх өргөдөл 12, Тэтгэмжтэй холбоотой өргөдөл 21, Сайн дурын даатгалтай холбоотой өргөдөл 4, Эрүүл мэндийн даатгалтай холбоотой 1, Талархал 1, Бусад асуудлын талаар 32 өргөдөл тус тус ирсэн ба 125-г хуулийн хугацаанд шийдвэрлэсэн, 5 өргөдөл шийдвэрлэх шатандаа явж байна.<br><br>Нийгмийн даатгалын газрын Тамгын газарт болон АЗДТГ-т 3 удаа өргөдөл хүсэлтийн тайлан хүргүүлж ажилласан. | |
| 4.1.3. | Нийгмийн даатгалын байгууллагын салбарын хэмжээнд архивын үйлчилгээг сайжруулах, ажил олгогч, иргэд, даатгуулагчид нийгмийн даатгалын үйлчилгээг чирэгдэлгүй, хөнгөн шуурхай үзүүлэх. | | Нийгмийн даатгалын газрын дотооддоо болон хэлтсүүд хооронд шимтгэл төлөлтийн лавлагааг цахимаар солилцох ажлыг зохион байгуулна. | Нийгмийн даатгалын болон архивын үйлчилгээг иргэд, хуулийн этгээд, даатгуулагчдад хөнгөн шуурхай, чирэгдэлгүй үзүүлсэн. | Архивын лавлагааг цахимаар солилцох боломжийг бүрдүүлсэн байна. | 2024 оны байдлаар бусад аймаг дүүрэг рүү 401 лавлагаа захиалан авсан, бусад аймаг, дүүргээс 174 лавлагаа ирсэн.<br><br>Нийтдээ 475 лавлагааг аймаг, дүүргийн хэлтсүүдтэй цахимаар солилцож нийгмийн даатгалын үйлчилгээг чирэгдэлгүй хөнгөн шуурхай хүргэж ажилласан. | |
| 4.1.4. | Батлагдсан орон тоо, төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулах. | | Төрийн албаны тухай хууль тогтоомж, журмын дагуу хүний | Хууль тогтоомжийн хүрээнд хүний нөөцийг бүрдүүлэх, тогтвор | Орон тоо, төсвийн хүрээнд хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг хууль тогтоомжийн дагуу гаргаж НДЕГ-т, | 2024 оны байдлаар Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд хүний нөөцийн томилгоог батлагдсан | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг гаргаж байна. | суурьшилтай ажиллах нөхцөл боломжоор хангах. | Аймгийн Тамгын газарт улирал бүр тайлагнасан байна. | төсөв орон тоонд багтаан А тушаал 40, Б тушаал 76 гаргаж ажилласан. Орон тооны хэтрэлт байхгүй, сул орон тоо 2 байна. ТАЗСЗөвлөл-д захиалга өгсөн бөгөөд 12 сард нөхөнгдөх төлөвтэй байна.<br>Монгол улсын Төрийн албаны зөвлөл 2024 оны 05 сард Орхон аймагт ажиллаж Төрийн байгууллагуудын Хүний нөөцийн үйл ажиллагаанд шалгалт явуулахад зөрчилгүй дүгнэлт авсан.<br>Орон тооны гүйцэтгэлийн мэдээг НДЕГ-т сар бүр, аймгийн ЗДТГ-т улирал бүр тайлагнан ажиллаж байна.<br>Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын 2024 оны А/51 тоот тушаалаар тус газрын бүтэц орон тоог 4 хэлтэс 1 тасаг 40 хүний орон тоотойгоор шинэчлэн баталсан. (ТЗ-35, ТҮ-4, ТҮМ-1)<br>. | |
| 4.1.5. | Газрын дотоод ажлыг сайжруулах чиглэлээр тодорхой, шинэлэг ажил зохион байгуулах, тайланг хүргүүлэх | | Ажлын байр /албан тушаал/-ын тодорхойлол тоор заагдсан чиг үүргийг хэрэгжүүлсэн байна. | Газрын ажилтан, албан хаагчдын ажлын байрны чиг үүрэг тодорхой болсон байх. | Газрын дотоод ажлыг сайжруулсан, шинэлэг ажил үйлчилгээ нэвтрүүлсэн талаар тайланг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ, Аймгийн Тамгын газарт хүргүүлнэ. | Нийгмийн даатгалын газар нь 2024 оны шинэлэг ажлын хүрээнд:<br>- Сэтгэл зүйн дархлаатай хамт олон болцгооё" хөтөлбөрийг 2024.02.01-2024.11.01 хүртэлх хугацаанд хэрэгжүүлэхээр батлан ажиллаж хагас жилийн байдлаар 4 арга хэмжээг хэрэгжүүлсэн.<br>- 2024 оны 02 болон 12 дугаар сард Монсертф ХХК тохирлын үнэлгээний байгууллагаас тус газрын хэрэгжүүлсэн ISO9001:2015 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Чанарын менежментийн тогтолцоо, ISO37001:2016 авлигын эсрэг менежментийн тогтолцооны хэрэгжилтэд Магадлах аудит хийж хангалттай үнэлгээ авч гэрчилгээг үргэлжлүүлэн хадгалуулахаар болсон.<br>- Бүтээмж, инновацийн зөвлөлөөс бүх албан хаагчдаас байгууллагын дотоод ажил сайжруулах кейзен санал авч шилдэг 7 шинэ санаачлагыг шалгаруулан 2024 онд хэрэгжүүлэхээр ажиллаж байна.<br>- Call pro үйлчилгээний дуудлагын цэсэнд шинээр ажил олгогч, иргэн гэсэн 2 цэс нэмж хүлээлгийн хугацаанд мэдээлэл хүргэдэг болсон.<br>- Сайн дурын даатгал болон ажил олгогчийн шимтгэлийн орлогыг төвлөрүүлэхдээ гүйлгээний утгыг буруу бичдэгээс шалтгаалан даатгуулагчийн шимтгэл тасрах бусад орлого нэмэгддэг. Тиймээс хамгийн олон давтамжтай гүйлгээ хийгддэг Хаан банкинд ЗГХЭГ болон НДЕГ-аар уламжлуулан интернет банкны цэсэнд өөрчлөлт хийлгэж АО, даатгуулагч даатгал төлөхөд регистрийн дугаар, утасны дугаар бичдэг болгон өөрчлүүлсэн.<br>- "Гэр бүл хүүхэд хөгжлийн хөтөлбөр" хэрэгжүүлэн ажиллаж Байгууллага дээрээ хүүхдийн өрөө шинээр гарган тохижуулж нээлт хийсэн. Эцэг эхээ ажлыг нь тартал цэцэрлэг, сургуулиа тараад гэртээ | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | харах хүнгүй хүүхдүүдийг эрсдэлд орохоос урьдчилан сэргийлж хичээл хийх болон бага насны хүүхдүүдийн танин мэдэхүй хөгжүүлэх тоглоом тоглох, монгол ардын уламжлалт тоглоом наадгайг багаас нь тоглуулж монгол ахуй өв соёлоо давхар суралцах нөхцөл боломжоор ханган тохижуулсан.<br>- "Эрүүл мэндийг дэмжигч байгууллага" хөтөлбөр хэрэгжүүлж тус газар нь хамт олон болон олон нийтийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх сургалт, сурталчилгааг тогтмол явуулах, нийгмийн сэтгэл зүйд нөлөөлхүйц эерэг хандлага түгээх, хөдөлгөөн өрнүүлэх нийгэмд үйлчлэх, нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэн эрүүл мэндийг дэмжигч байгууллага, эрүүл ажлын байр бий болгохоор зорилт тавин ажиллаж амжилттай хэрэгжүүллээ. | |
| 4.1.6. | Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг дунд хугацаагаар төлөвлөн боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах. | | Газрын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангасан байна. | Ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр боловсруулан баталж, хэрэгжүүлнэ. | Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг дунд хугацааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, үр дүнг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт тайлагнасан байна. | Нийгмийн даатгалын газрын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангах асуудлаар судалгаа хийж, бүртгэлжүүлсэний үндсэн дээр дунд хугацааны хөтөлбөр боловсруулан ажиллаж "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 7.1-д "Ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах төлөвлөгөө"-г жил бүр батлан хэрэгжүүлнэ гэж заасны дагуу оны эхэнд төлөвлөгөө боловсруулан газрын даргаар батлуулан ажиллаж байна. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Албан хаагч, ажилтан бүрт зохих журмын дагуу цалинтай болон цалингүй чөлөө өгч, сурч боловсрох нөхцөл боломжоор ханган дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.<br>2024 оны байдлаар жилийн байдлаар ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд 4.724.300 мянган төгрөгийн буцалтгүй тусламж, дэмжлэг үзүүлж ажилласан байна.<br>2024 оны эжилд Монголын бүтээмжийн төвийн мэргэжилтэн бэлтгэх сургалтад 2 албан хаагч (Н.Хулан, Д.Цэгмид)-ийг, мөн Филипин улсад 1 албан хаагчийг (Н.Бат-Эрдэнэ) тус тус сургалтад хамруулсан.<br>Гэр бүлийн боловсролын сургагч багш бэлтгэх 8 модуль 56 цагийн сургалтад 2 албан хаагчийг хамруулсан.<br>Мөн Албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих зорилгоор "Орхон эм хангамж ХХК"-тай хамтан ажиллаж хөнгөлөлттэй амин дэм, витаминаар хангаж ажилласан.<br>Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад 2 албан хаагчийг, Мэргэшүүлэх дунд хугацааны сургалт 1 албан хаагчийг тус тус хамруулсан.<br>Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолын дагуу ТЗ-ны 15 албан хаагчид 101,120,104 сая | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төгрөгийн урамшуулал олгосон. | |
